

МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх,
хамгаалах журам батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.5 дахь хэсэг, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1.“Саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Саналын хуудас хүлээн авсан тухай тэмдэглэлийн загвар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Саналын хуудас хүлээн авсан тухай мэдээний маягт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Саналын хуудасны зарцуулалтын тайлангийн маягт”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Салбар комисст хүргүүлсэн саналын хуудасны зарцуулалтын тайлангийн маягт”-ыг 5 дугаар хавсралтаар, “Санал авах байранд хүргүүлсэн саналын хуудасны зарцуулалтын тайлангийн маягт”-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн Ерөнхий Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хамгаалах журам батлах тухай” 59 дүгээр тогтоол, 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам батлах тухай” 151 дүгээр тогтоол, 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам батлах тухай” 27 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

САНАЛЫН ХУУДСЫГ ХЭВЛҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, ХҮРГҮҮЛЭХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн болон ард нийтийн санал асуулгын саналын хуудас /цаашид “саналын хуудас” гэх/-ыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Аймаг, нийслэлийн сонгуулийн нь хороо аймаг, нийслэлийн ээлжит сонгуулийн саналын хуудасны тоог аймаг, нийслэл, сум, дүүрэг, аймгийн төвийн баг, хороо, хэсэг тус бүрээр гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

1.3.Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо болон 1.2-т заасан тоог харгалзан Сонгуулийн Ерөнхий Хороо саналын хуудасны тоог тогтооно.

1.4.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороо болон санал авах байранд хүргүүлэх саналын хуудасны тоог тооцон гаргаж хуралдаанаараа батална.

1.5.Ээлжит сонгуулиас бусад орон нутгийн хурлын сонгуулийн саналын хуудсыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо эрхлэн хэвлүүлэх ба саналын хуудасны тоог тогтооно. Сонгуулийн Ерөнхий Хороо саналын хуудас хэвлүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

1.6.Ээлжит сонгуулиас бусад орон нутгийн хурлын сонгуульд сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэхээр шийдвэрлэсэн бол саналын хуудсыг Сонгуулийн Ерөнхий Хороо энэ журамд нийцүүлэн эрхлэн хэвлүүлнэ.

1.7.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн саналын хуудасны эхийг баталсан загварын дагуу бэлтгэн, үнэн зөв болохыг баталгаажуулж Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

1.8.Ард нийтийн санал асуулгыг дангаар явуулах тохиолдолд түүнд хэрэглэгдэх саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах үйл ажиллагааг энэхүү журамд нийцүүлэн зохион байгуулна.

Хоёр. Саналын хуудсыг хэвлүүлэх

2.1.Энэ журмын 1.4-т зааснаас бусад саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах ажлыг Сонгуулийн Ерөнхий Хорооноос байгуулсан Ажлын хэсэг эрхлэн зохион байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хорооны гишүүд,

Ажлын албаны ажилтнууд болон холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулна.

2.2.Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль тус бүрээр саналын хуудасны загварыг Сонгуулийн Ерөнхий Хороо батална.

2.3.Саналын хуудсыг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргэсэн байхаар тооцож хэвлүүлнэ.

2.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус сонгуулийн саналын хуудасны хэвлэлийн эхийг Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан загварын дагуу бэлтгэх бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооноос байгуулсан Ажлын хэсэг хянан баталгаажуулж, хэвлэх зөвшөөрөл олгоно.

2.5.Нам, эвсэл, хамтарсан намууд, төрийн бус байгууллагын төлөөлөл саналын хуудсыг хэвлэх явцыг Сонгуулийн Ерөнхий Хороонд бичгээр хүсэлт гарган ажиглаж болно.

2.6.Саналын хуудасны эх бэлтгэл, хэвлэх, боож баглах, хүлээлцэх явцад хэвлэх үйлдвэрийн ажилчдаас гадна Ажлын хэсгийн гишүүд, нам, эвсэл, хамтарсан нам, төрийн бус байгууллагын ажиглагч, харуул, хамгаалалтын ажилтнаас өөр хүн байхыг хориглоно.

2.7.Саналын хуудсыг баталсан загвар, захиалсан тоо, чанар, шаардлагын дагуу хэвлэж буй эсэхэд Ажлын хэсэг хяналт тавина.

2.8.Саналын хуудсыг хэвлэж дууссан даруй хэвлэх үйлдвэрээс албан ёсоор томилогдсон албан тушаалтан батлагдсан загвар, тоо ёсоор хэвлэлийн эхтэй нь тулган үзэж Ажлын хэсэгт хүлээлгэн өгч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Уг үйл ажиллагаанд нам, эвсэл, хамтарсан нам болон төрийн бус байгууллагын ажиглагчид байлцаж болно.

2.9.Аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр хэвлэсэн саналын хуудсыг боож хайрцаглан, хайрцагны хоёр хажууд хайрцаг тус бүрийн дугаар, түүнд байгаа саналын хуудасны тоо, аймаг, сум, дүүргийн нэр зэргийг бичиж аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод хүлээлгэн өгөх хүртэл хэвлэх үйлдвэрийн байранд лацдан, хамгаалалтын дор хадгална.

2.10.Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрлаж буй гадаад улсад хүргүүлэх саналын хуудсыг боож хайрцаглан, хайрцагны хоёр хажууд хайрцаг тус бүрийн дугаар, саналын хуудасны тоо, хүргэх улсын нэр, хаяг, хүлээн авах хүний нэр, албан тушаал, утасны дугаар зэргийг бичиж тухайн гадаад улсад илгээх дипломат шууданд хүргэх албан тушаалтан хүлээн авах хүртэл хэвлэх үйлдвэрийн байранд лацдан, хамгаалалтын дор хадгална.

2.11.Саналын хуудсыг хэвлүүлж дууссаны дараа хэвлэлтийн явцад гарсан гологдол саналын хуудсыг устгах ажлыг ажиглагчдыг байлцуулан ажлын хэсэг зохион байгуулж тэмдэглэл үйлдэнэ.

2.12.Саналын хуудсыг хэвлэж дууссаны дараа саналын хуудасны хэвлэлийн эх, компьютерийн файлыг нам, хамтарсан нам, эвслийн болон төрийн бус байгууллагын ажиглагчдыг байлцуулан тухай бүр устгах ажлыг Ажлын хэсэг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн сонгуулийн бусад баримтын хамт холбогдох журмын дагуу архивт хадгалуулна.

Гурав. Саналын хуудсыг хүргүүлэх

3.1.Ажлын хэсэг нь батлагдсан загвараар хэвлүүлсэн саналын хуудсыг хуваарийн дагуу аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороогоор дамжуулан санал авах байранд санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байхаар тооцож саналын хуудсыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.

3.2.Саналын хуудас хэвлэх үйлдвэрт аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл биечлэн ирж Сонгуулийн Ерөнхий Хорооны зөвшөөрөлтэйгөөр саналын хуудсыг хүлээн авна. Биечлэн ирэх боломжгүй тохиолдолд саналын хуудсыг холбогдох сонгуулийн хороонд хүргүүлэх ажлыг Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын хэсэг зохион байгуулна.

3.3.Сум, дүүргийн сонгуулийн хорооны дарга болон 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос саналыг хуудсыг хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, хүлээн авахад байлцсан төлөөлөл гарын үсэг зурна.

3.4.Санал авах байрны ахлах болон зохион байгуулагчид нь сум, дүүргийн сонгуулийн хорооноос саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ нэг бүрчлэн тоолж хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, хүлээн авахад байлцсан дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид гарын үсэг зурж харьяа дээд шатны сонгуулийн хороонд саналын хуудсыг бүрэн гүйцэд хүлээн авсан эсэх талаар мэдэгдэнэ.

3.5.Нам, эвсэл, хамтарсан нам, нэр дэвшигчийн ажиглагч холбогдох сонгуулийн байгууллагад хүсэлт гаргаж, саналын хуудсыг хүлээлцэх ажиллагаанд байлцаж болно.

3.6.Сонгуулийн хороо саналын хуудсыг хүргүүлэх, хүлээн авах ажиллагааг цагдаагийн хамгаалалтын дор гүйцэтгэнэ.

3.7.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах саналын хуудсыг Төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө салбар комисст дипломат шуудангаар хүргүүлнэ.

3.8.Салбар комиссын ахлах болон зохион байгуулагчид нь Төв комиссоос саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ нэг бүрчлэн тоолон хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, хүлээн авахад байлцсан Төв комиссын итгэмжлэгдсэн төлөөлөгч, салбар комиссын ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид гарын үсэг зурна.

Дөрөв. Саналын хуудсыг хадгалах, хамгаалах

4.1.Санал авах байранд саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.

4.2.Санал авах байрны ахлах зохион байгуулагч бусад зохион байгуулагчдыг байлцуулан саналын хуудаст тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд уг ажиллагааг хийж гүйцэтгэсний дараа саналын хуудсыг боож лацдан гал, усны болон гэнэтийн аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэн, цагдаагийн хамгаалалтанд битүүмжлэн хадгална.

4.3.Санал авах байрны ахлах зохион байгуулагч нь санал хураалтын дүн гарсны дараа зарцуулагдаагүй үлдсэн, буруу тэмдэглэл хийснээс болон санал тоолох төхөөрөмж уншаагүйгээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь багцлан боож битүүмжлэн, зориулалтын уутанд хийж сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

4.4.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хорооноос, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байрнаас саналын хуудсыг хүлээн авч тэмдэглэл үйлдэх бөгөөд битүүмжилсэн баглаа боодлыг задалж, зориулалтын уутнаас нь гаргахыг хориглоно.

4.5.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь хүлээн авсан бүх саналын хуудсыг зохих журмын дагуу аймаг, нийслэлийн архивт хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд аюулгүй байдалд хадгална.

Тав. Саналын хуудасны зарцуулалтад тавих хяналт

5.1.Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах үед болон санал авах өдөр хэрэглэсэн саналын хуудасны зарцуулалтад аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид болон ажиглагчид хяналт тавина.

5.2.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн саналын хуудасны зарцуулалтын тайланг нэгтгэж аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг сонгуулийн санал авах байр тус бүрээр гаргуулан авч нэгтгэн Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлнэ.

5.3.Төв комисс нь Гадаад улсад байгаа сонгогчдын санал хураалт дууссаны дараа салбар комиссоос ирүүлсэн саналын хуудасны зарцуулалтын тайланг салбар комисс тус бүрээр гаргуулан авч нэгтгэн Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлнэ.

Зургаа. Саналын хуудсыг архивт хадгалах

6.1.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо саналын хуудсыг баримтын дагуу аймаг, нийслэлийн архивт тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгч, санал хураалт дууссан өдрөөс хойш хоёр жилийн хугацаагаар хадгалуулна.

6.2.Аймаг, нийслэлийн архив нь битүүмжилсэн саналын хуудсыг нууцын журмаар хадгалах бөгөөд битүүмжилсэн саналын хуудасны баглаа, боодлыг задлах, устгахыг хориглоно.

6.3.Саналын хуудсыг дахин тоолох тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд саналын хуудасны баглаа боодлыг задлах бөгөөд уг үйл ажиллагаанд санал авах байрны болон аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын төлөөллийг байлцуулна. Дээрх сонгуулийн хороодын бүрэн эрхийг дуусгавар болгосон бол Сонгуулийн Ерөнхий Хорооны төлөөллийг байлцуулна.

6.4.Саналын хуудсыг архивт хадгалах хугацаа дууссанаас хойш саналын хуудасны битүүмжлэлийг нээх тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд саналын хуудасны зурган файлыг ашиглуулна.

6.5.Сонгуулийн Ерөнхий Хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв нь санал хураалт дууссаны дараа сонгуульд ашигласан санал тоолох төхөөрөмж бүрт уншигдсан саналын хуудасны зурган файлыг тусгай хаягжилт бүхий цахим сан үүсгэж хадгална. Цахим сангийн ашиглалт, хадгалалтыг зөвхөн Мэдээллийн технологийн төвийн захирлын эрх олгосон албан хаагч хариуцаж ажиллана.

6.6.Хадгалах хугацаа нь дууссан саналын хуудсыг Сонгуулийн Ерөнхий Хороонд мэдэгдэн зөвшөөрөл авсны дараа аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилсон Ажлын хэсэг устгах ажлыг зохион байгуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

6.7.Саналын хуудсыг хадгалах үүрэг бүхий албан тушаалтан түүнийг алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага, сонгуулийн тухайн шатны хороод болон Сонгуулийн Ерөнхий Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

6.8.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороод энэхүү журмын 6.1-д заасан тэмдэглэлийн хувийг, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилсон Ажлын хэсэг, мөн журмын 6.6-т заасан тэмдэглэлийн хувийг тус тус Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

Долоо Хариуцлага

7.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

(Энэ журамд 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**САНАЛЫН ХУУДАС ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

20... оны ... дугаар
сарын-ны өдөр

..... сонгуулийн хороо

1. Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан дугаарын баглаа, боодолтой ширхэг саналын хуудсыг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнтэй хүлээн авав.

2. Битүүмжлэл, лацны дугаар хөндөгдөөгүй, саналын хуудас гэмтээгүй байсан болно.

Саналын хуудсыг хүлээн авсан:

Сонгуулийн хорооны дарга /Ахлах зохион байгуулагч/

Нарийн бичгийн дарга /Зохион байгуулагчид/

Гишүүд

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

САНАЛЫН ХУУДАС ХҮЛЭЭН АВСАН МЭДЭЭ

20.... оны ... дугаар
сарын-ны өдөр

№	Сум, дүүрэг болон сонгуулийн хэсэг дэх санал авах нэгж	Саналын хуудасны тоо, ширхэг		Зөрүү /+/ илүү /-/ дутуу	Баглаа, боодлын дугаар	Битүүмжлэл, лацны талаарх тэмдэглэл
		хуваарилсан	хүлээн авсан			
1						
2						
3						
4						
5						
6						
...						

Саналын хуудас хүлээлгэн өгсөн:

Албан тушаал:

Нэр:

Гарын үсэг:

Саналын хуудас хүлээн авсан:

Албан тушаал:

Нэр:

Гарын үсэг:

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

..... аймаг, нийслэлийн сум, дүүргийн сонгуулийн хороо

20.... оны дугаар
сарын-ны өдөр

№	Сонгуулийн хэсэг дэх санал авах байр	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Саналын хуудасны тоо			Санал хураалтад зарцуулсан саналын хуудасны тоо	Үүнээс			Зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны тоо
			хуваарилагдсан	хүлээн авсан	зөрүү /+/ илүү /-/дутуу		сонгогч буруу тэмдэглэл хийснээс болон санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүйгээс хүчингүй болгосон	зөөврийн битүүм-жилсэн саналын хайрцгаар санал авахад	санал авах өдөр санал тоолох төхөөрөмжөөр санал авахад	
1	... сонгуулийн хэсгийн санал авах байр									
2	... сонгуулийн хэсгийн санал авах байр									
 сум, дүүргийн дүн									
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ДҮН										

Тэмдэг
Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга
Нарийн бичгийн дарга

/...../

/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

..... УЛСЫН ХОТОД БАЙГАА САЛБАР КОМИССТ ХҮРГҮҮЛСЭН
САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

..... улс

20..... оны дугаар
сарын-ны өдөр

№	Салбар комисс	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Саналын хуудасны тоо			Санал хураалтад зарцуулсан саналын хуудасны тоо	Үүнээс		Зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны тоо
			хуваарилагдсан	хүлээн авсан	зөрүү /+/ илүү /-/дутуу		сонгогч буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болгосон	санал авах өдөр санал авахад	
1									

Тэмдэг

Салбар комиссын ахлах зохион байгуулагч

/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
17 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

САНАЛ АВАХ БАЙРАНД ХҮРГҮҮЛСЭН САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

..... аймаг, нийслэлийн сум, дүүргийн хэсэг дэх санал авах байр

20.... оны дугаар
сарын-ны өдөр

№	... сонгуулийн хэсэг дэх санал авах байр	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Саналын хуудасны тоо			Санал хураалтад зарцуулсан саналын хуудасны тоо	Үүнээс			Зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны тоо
			хуваарилагдсан	хүлээн авсан	зөрүү /+/ илүү /-/дутуу		сонгогч буруу тэмдэглэл хийснээс болон санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүйгээс хүчингүй болгосон	зөөврийн битүүм-жилсэн саналын хайрцгаар санал авахад	санал авах өдөр санал тоолох төхөөрөмжөөр санал авахад	
ДҮН										

Тэмдэг

Ахлах зохион байгуулагч

/...../